

Улсын бүртгэлийн ерөнхий газрын ёс зүйн дэд хорооны 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан

2024.06.25

Улаанбаатар хот

“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс хүчин төгөлдөр болсноор Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/1713 дугаар тушаалаар “Ёс зүйн зөвлөл”-ийг “Ёс зүйн дэд хороо” болгон өөрчилсөн.

Ёс зүйн дэд хороо 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар ёс зүйн зөрчилтэй холбоотой 8 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэн, "Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төв"-д ирүүлсэн албан хаагчдын ёс зүйтэй холбогдолтой 15 гомдлын шийдвэрлэлтийг зохих журмын дагуу шийдвэрлэсэн эсэхэд хяналт тавин гишүүд хуваарийн дагуу шалгасан. Гомдлын шийдвэрлэлтийн байдалд дүгнэлт хийж, холбогдох албан тушаалтанд заавар чиглэлийг хүргүүлсэн.

Мөн 2024 оны 03 дугаар сард Ёс зүйн хороонд “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024-2030)”-ийн төсөлд тусгах санал боловсруулан хүргүүлсэн бөгөөд тус хөтөлбөр Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдан ирснийг бүх гишүүдэд танилцуулан, байгууллагын цахим хуудаст байршуулсан.

Ёс зүйн дэд хорооны гишүүдийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 06 дугаар сард Калифорнийн Их Сургуулийн сэтгэл зүйн магистр, ШУТИСургуулийн Сэтгэл зүйн тэнхимийн багш Б.Баярмаа “Ёс зүй ба харилцаа” сэдэвт сургалтыг цахимаар зохион байгуулж бүх гишүүдийг хамруулсан.

Ёс зүйн дэд хороонд 2024 онд ирүүлсэн зөрчлүүдийн шинжлэн нэгтгэн дүгнэвэл хүнд суртал, харилцааны доголдол зэрэг илэрч байна. Алба хаагчдыг чадавхжуулах, ёс зүйн хэм хэмжээний талаар сургалтыг давтамжтай зохион байгуулах шаардлагатай байна.